

# Нийгмийн эгэх хариуцлага

УЛИРАЛ ТУТМЫН МЭДЭЭЛЛИЙН СОНИН БИЧИГ




Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development and Cooperation SDC  
Швейцарын хөгжлийн агентлаг



GLOBAL PARTNERSHIP FOR SOCIAL ACCOUNTABILITY



ДЭЛХИЙН БАНК  
ОУСБХБ • ОУХА | ДЭЛХИЙН БАНК ГРУПП

**"МОНГОЛ УЛСАД ИЛ ТОД БАЙДАЛ, ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХЭД НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ" (MASAM II) ТӨСӨЛ**

**Mainstreaming Social Accountability for Improved Transparency and Participation in Mongolia (MASAM II Phase)**



ГЛОБ  
ИНТЕРНЭШНЛ  
ТӨВ



Save the Children



World Vision  
Дэлхийн Зөн Монгол

## ЭНЭ ДУГААРТ

### Иргэд, иргэний нийгмийн байгууллагууд болон төрийн байгууллагуудын төлөөллийг чадавхжуулах сургалтууд үргэлжилж байна

ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ  
.....

СУРГАЛТЫН МОДУЛИУД  
.....

ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА  
.....

СУУРЬ СУДАЛГАА  
.....

ТӨЛӨВЛӨГӨӨТ ҮЙЛ АЖИЛЛАГАА  
.....

"Монгол Улсад ил тод байдал, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь" буюу MASAM II төслийг Швейцарын хөгжлийн агентлаг, Нийгмийн эгэх хариуцлагын дэлхийн түншлэлийн санхүүжилтээр, Дэлхийн Банкнаас хэрэгжүүлж байна.

Хамтран хэрэгжүүлэгчээр Глоб Интернэшнл төв (ГИТ) ТББ, Дэлхийн Зөн Монгол ОУБ, Японы Хүүхдийг Ивээх Сан ажиллаж байна.

Тус гурван байгууллагаас Дэлхийн Банкны зөвлөхүүдтэй хамтран боловсруулсан дөрвөн модулийг ашиглан, "Төсвийн үйл явцад нийгмийн эгэх хариуцлагын ойлголт, арга хэрэгслүүдийг ашиглах нь" сургалт зохион байгуулж байна. Тус сургалтыг Өвөрхангай, Говьсүмбэр, Сэлэнгэ аймгуудад 10 дугаар сарын 26-наас 11 дүгээр сарын 12-ныг хүртэл цахимаар хийсэн бөгөөд иргэд, иргэний нийгмийн байгууллага, төрийн байгууллагуудын төлөөлөл зэрэг нийт 100 гаруй хүн оролцов. Иргэд, ИНБ-ууд болон төрийн байгууллагуудын ажилтнуудыг чадавхжуулах зорилготой уг сургалт 2022 оны 2 дугаар сарыг дуустал хийгдэх бөгөөд 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн гурван талын (иргэн-ИНБ-төр) оролцоог хангахыг зорьж байна.

# СУРГАЛТЫН МОДУЛИУД

**Модуль 1**

Төрийн үйлчилгээг сайжруулахад нийгмийн эгэх хариуцлага ба төсвийн ил тод байдлыг цогцоор ашиглах нь

MAINSTREAMING SOCIAL ACCOUNTABILITY IN MONGOLIA PROGRAM  
**MASAM**



**Модуль 2**

Монгол Улсын төсвийг тодорхойлох нь: Төсвийн өгөгдөлд нээлттэй хандах/нэвтрэх

MAINSTREAMING SOCIAL ACCOUNTABILITY IN MONGOLIA PROGRAM  
**MASAM**



**Модуль 3**

Практик дадлага I: Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагад иргэдийн оролцоо


MAINSTREAMING SOCIAL ACCOUNTABILITY IN MONGOLIA PROGRAM  
**MASAM**



**Модуль 4**

Практик дадлага II: Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний төсөв болон үйлчилгээний хүртээмжийн оролцоот хяналт

MAINSTREAMING SOCIAL ACCOUNTABILITY IN MONGOLIA PROGRAM  
**MASAM**



## ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### ЦАХИМ ХАКАТОН

Төслийн хүрээнд хийгдсэн онцлох үйл ажиллагаа нь хоёр чиглэлээр зохион байгуулсан Хакатон тэмцээн юм. Уг цахим хакатонд зориулсан асуудал тодорхойлох цахим уулзалтуудыг 21 аймаг болон нийслэлийн 9 дүүргийн иргэний ИНБ-уудын төлөөлөл, төрийн байцгууллагын холбогдох дарга, мэргэжилтнүүд төдийгүй Эрүүл мэндийн яам, Сангийн яамны төлөөллүүдийг оролцуулан зохион байгуулав. Тухайлбал, “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага (ТХОУ)-д иргэдийн оролцоог хангах нь” сэдэвт асуудал тодорхойлох уулзалтыг 2021 оны 10 дугаар сарын 5, 6-нд цахимаар зохион байгуулав. Эхний уулзалтад Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалт, Төрийн сан, Санхүүгийн хяналт, эрсдлийн удирдлага, Мэдээллийн технологи зэрэг газрын мэргэжилтнүүд болон Үндэсний хөгжлийн газар, Аудитын үндэсний газар, Авлигатай тэмцэх газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар зэрэг төрийн байгууллагуудын, мөн түүнчлэн Удирдлагын академи зэрэг шинжлэх ухааны байгууллагуудын төлөөлөл зэрэг нийт 55 хүн оролцсон бол 2 дахь өдрийн уулзалтад нийт 16 аймаг, хоёр дүүргийн төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллүүд оролцлоо.

### ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААРХ АСУУДАЛ ТОДОРХОЙЛОХ ЦАХИМ УУЛЗАЛТ

Төсвийн хөрөнгө оруулалтад иргэдийн оролцоог хангах нь цахим уулзалтыг төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой дараах асуудалд оролцогсдоос хариулт авах хэлбэрээр зохион байгуулав.

Үүнд:

- Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагад иргэдийн оролцоог хангах шаардлага ба арга замуудыг тодорхойлох
- Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагад иргэд оролцоход учирдаг саад бэрхшээлийг илрүүлэх
- Иргэдийн оролцоог бүрэн хангахад тохиромжтой цахим платформыг бий болгох
- Дээрх асуудлаар иргэдэд тулгардаг хүндрэл бэрхшээлийг илрүүлэх зэрэг болно.

#### Асуудал тодорхойлох цахим уулзалтын зорилго

- Нийслэл хот болон 21 аймгийн хэмжээнд төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөн хэрэгжүүлэхдээ иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах, тэдгээрт дүн шинжилгээ хийхэд төр болон иргэний нийгмийн байгууллагуудад учирч буй саад бэрхшээлийг олж илрүүлэх.

- Өнөөгийн нөхцөлд төсвийн хөрөнгө оруулалтын талаарх баримт, мэдээллийг түгээдэг цахим платформыг ашиглахад тулгардаг бэрхшээлтэй асуудлыг тодорхойлоход оршиж байв.

***“Төр - иргэн хоёрын харилцааг ойртуулахын төлөө ил тод байдлыг хангах, иргэдийн санал хүсэлтийг уламжлалч чадах технологийн шийдлийг хөгжүүлэх”***

Уулзалтын эцэст, мэдээлэл дутмаг байдгаас үүдэн төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагад иргэдийн оролцоо сул, үр дүн муутай, иргэдийн тавьсан санал, хүсэлтээс үр дүн гардаггүй тул үйл явцад оролцох сонирхол бага байдаг учраас засгийн газар-иргэн хоорондын харилцааг ойртуулж, ил тод байдлыг хангах, санал хүсэлтийг уламжлах технологийн шийдлийг хөгжүүлэх шаардлагатайг онцлон дурдав.

## ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### ЦАХИМ ХАКАТОН


Төслийн хүрээнд хийгдсэн онцлох үйл ажиллагаа болох хоёр чиглэлээр зохиогдсон Хакатон тэмцээний эхний нь эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг сайжруулах зорилготой. "Анхан шатны тусламж, үйлчилгээг иргэдэд ойртуулах нь" сэдэвт уг цахим хакатоныг 2021 оны 6 дугаар сарын 19-20-нд зохион байгуулсан бөгөөд:

- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэх, тэдний оролцоог дэмжих,
- Олон нийтэд нээлттэй эх сурвалжаас мэдээлэл цуглуулж, цахим платформд мэдээллийг нэгтгэх,
- Засгийн газар-иргэн хоорондын харилцааг ойртуулж, ил тод байдлыг хангах, иргэдийн санал хүсэлтийг уламжлах технологийн шийдлийг хөгжүүлэхийг зорив.

2021 оны 10 дугаар сарын 15-17-нд зохион байгуулагдсан хоёр дахь буюу "Иргэдийн төлөө төсвийн хөрөнгө оруулалт" цахим хакатон

- Иргэдэд төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийг ил тод, нээлттэй хэлбэрээр хүргэх,
- Иргэдээс санал хүсэлт хүлээн авах, үнэлгээ өгөх боломж бүхий цахим платформын загвар гаргах зорилготой байв.

### АСУУДАЛ БА ТЕХНОЛОГИЙН ШИЙДЭЛ



**"Чирон" баг гар утасны апп** - Эрүүл мэндийн үзлэгийн хуваарийн дагуу урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, эрт илрүүлгийн талаар цогц мэдээлэл хүлээн авч, улмаар анхан шатны тусламж үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт, асуудлыг шийдвэр гаргагчдад илгээх шийдлийг санал болгосон. Мөн хэрэглэгчийн үзлэгийн түүх, шинжилгээний хариу, эмийн жорын мэдээллийг архивлан хадгалж, дата сан бүрдүүлэх болон алслагдсан бүс нутагт, интернэтгүй үед ч ашиглах боломжтой зэрэг давуу талаараа онцлог.

Эрт илрүүлгийг чиглүүлэх алгоритм ашиглан өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, зөвлөмж хүргэх, газрын зураг ашиглан эмнэлгийн тусламж үйлчилгээний үнэлгээний систем боловсруулах шийдэл. **"Хөөрхөн" багийн** санал болгосон шийдэл нь гар утсаар дамжуулан аливаа эмнэлгийн байршил, мэдээллийг сонгож, түүний үйлчилгээний чанар, мэргэжлийн ёс зүй, орчны тохижилт зэрэгт үнэлгээ өгч, улмаар санал хүсэлт илгээх болон хүлээн авах боломжтой систем.




**"Bid" апп** нь нэг кодоор бүх платформд ажиллах боломжтойгоос гадна QR уншуулан төсвийн хөрөнгө оруулалтын талаарх бүхий л мэдээлэл авах боломжтой тул маш хялбар, зардал багатай шийдэл юм. Мөн нээлттэй, хялбар мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчийг **e-mongolia, ebarimt** системээр танин, байршлыг нь тодорхойлох, улсын төсвийн хөрөнгө оруулалтын үе шатуудад иргэдийн саналыг авах, хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээнд үнэлгээ өгөх боломжийг бүрдүүлэх шийдэл дэвшүүлсэн.

Иргэдийн санал хүсэлтийн тандалт судалгааны **"Shiid" апп**. Энэхүү апп-ын үндсэн зорилго нь төрийн болон хувийн байгууллагуудын талаарх иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэх юм. Мөн иргэдийн санал өгөх зан төлвийг дэмжих, төрөөс хэрэгжүүлж буй төслийн талаарх мэдээллийг иргэдэд түгээх, өгсөн саналын хойноос тандаж асуух, төр, хувийн хэвшлийн байгууллагуудын шударга ерсөлдөөний үйл явцыг ил тод болгох зорилготой.

## СУУРЬ СУДАЛГАА

МАСАМ II төслийн хүрээнд хийсэн суурь судалгааны үр дүн

Таны ажиллаж буй байгууллага орон нутгийн иргэдэд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдэд төсөв хэрхэн хуваарилж, ашигладаг тухай мэдээлдэг үү?




### Судалгаанаас гарсан дүгнэлт

Суурь судалгааны үр дүнгээс үндсэн **3** дүгнэлт гарч байна.

- Иргэд, ИНБ болоод төрийн байгууллагуудын хооронд **үл ойлголцол их** байгаа нь мэдээллийн зөрүүтэй, хүртээмжтэй бус, ойлгомжгүй байдал гол хүчин зүйл болж байна.
- Иргэд, ИНБ, төрийн байгууллагынхныг тухайн салбарын болоод мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-той холбоотой асуудлаар **мэдлэгжүүлэх, чадавхжуулах** хэрэгцээ буйг бүх талууд хүлээн зөвшөөрөв. Үүнд, ИНБ-ынхны санал санаачилга, бүтээлч оролцоо нь үр дүнд хүргэх гол түлхэц болно гэж төрийн байгууллагын төлөөллүүд үзэж байна.
- Иргэд, ИНБ болоод төрийн байгууллагууд үр дүнтэй **хамтран ажиллах** нь чухал болохыг харуулж байна.

Хэрвээ **ТИЙМ** бол, мэдээллээ хэрхэн хуваалцдаг вэ?



## ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

### ТООН/ЧАНАРЫН СУДАЛГАА

Хамарсан сэдэв:

- Эрүүл мэнд
- Төсвийн хөрөнгө оруулалт

Тоон судалгаа хийгдсэн орон нутаг:

- Улаанбаатар хотын 9 дүүрэг
- 11 аймаг (Архангай, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Завхан, Орхон, Сүхбаатар, Сэлэнгэ, Ховд, Хөвсгөл)

Тоон судалгаанд хамрагдсан хүний тоо:

- Эрүүл мэнд - 406
- Төсвийн хөрөнгө оруулалт - 418

Чанарын судалгаа хийгдсэн орон нутаг:

- 9 дүүрэг
- 21 аймаг

Чанарын судалгаанд хамрагдсан хүний тоо:

- Эрүүл мэнд - 30
- Төсвийн хөрөнгө оруулалт - 30
- ИНБ - 30

# СУУРЬ СУДАЛГАА

## СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Та төрийн байгууллагын иргэдэд хүргэж буй төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой мэдээллийг хэр ил тод гэж бодож байна вэ?




Та мэдээлэл хүргэх зорилготой төрийн байгууллагуудын албан ёсны веб хуудаснууд байдгийг мэдэх үү?

<https://publicinvestment.gov.mn>  
<http://www.mof.gov.mn>  
<http://www.iltod.gov.mn>  
<http://onhs.mof.gov.mn>



Та эдгээр веб хуудасуудаар сүүлийн 12 сарын хугацаанд зочилж байсан үү?




Та дараах мэдээллүүдийн талаар мэдэх үү?



Таны бодлоор, үг [Аймаг/Сум/Дүүрэг]- т төсвийн хөрөнгө оруулалттай төслүүдийг төлөвлөх, хяналт шинжилгээ хийхэд иргэдийн оролцоо чухал үү?



Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөлтэй (төсвийн хөрөнгө) холбоотой шийдвэр гаргах процесст оролцож байсан туршлагаа хуваалцана үү?



## Төрийн байгууллагуудад өгөх ЗӨВЛӨМЖ

Төрийн байгууллагууд дараах үндсэн **дөрвөн** чиглэлээр ажиллах нь үр дүнтэйг суурь судалгаа харуулж байна.



### Нэг. Үр дүнд суурилсан хамтын ажиллагааг эхлүүлэх/бэхжүүлэх

- Иргэдийн оролцоог дэмжсэн арга, механизмуудаа тогтмол сайжруулах
- Төсвийн хөрөнгө оруулалт, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг сайжруулах санаачилгыг үр дүнтэй хэрэгжүүлэх гурван талт /иргэд-ИНБ-төр/ оролцоог харуулсан зураглал гаргаж, хамтдаа мөрдөн ажиллах
- Иргэдээс ирүүлсэн санал, хүсэлтийг ил тод байлгаж, хариу үйлдэл буюу шийдвэрлэж буй үйл явцаа ил тод, нээлттэй, хариуцлагатайгаар олон нийтэд цаг тухайд нь мэдээлэх, тайлагнах
- Иргэд, ИНБ-ын оролцоог МХХТ-ийн хэрэглэгдэхүүнээр хангах
- Мэдээлэл цуглуулах, шинжлэх, үр дүнг нь шийдвэр гаргах үйл явцад тусгасан эсэх нь тодорхой байх

### Хоёр. МХХТ-ийг үр дүнтэй ашиглах

- Одоогоор ашиглаж буй өөрсдийн цахим болон олон нийтийн сүлжээ хуудсныхаа төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой мэдээ мэдээлэл, эх сурвалжуудыг тогтмол шинэчлэх,
- Мэдээллээ ойлгомжтой, хүртээмжтэй байхад ямагт анхаарах
- Залуучуудад хүрэх, тэднийг идэвхжүүлэхийг нэн тэргүүний зорилт болгох

## СУУРЬ СУДАЛГАА

### Төрийн байгууллагуудад өгөх ЗӨВЛӨМЖ

Төрийн байгууллагууд дараах үндсэн **дөрвөн** чиглэлээр ажиллах нь үр дүнтэйг суурь судалгаа харуулж байна.

#### Гурав. Сурталчлан таниулах

- Одоогоор хэрэглэж буй арга, механизм, хэрэглэгдэхүүнүүдээ сайтар сурталчлах
- Оролцоо дутмаг буй нас (залуучууд буюу 35-55 нас), хүйсийн (эрэгтэйчүүд) бүлгийн онцлогийг харгалзан, харилцах хуудас, харилцааны арга хэлбэр, платформыг зөв сонгож, эсвэл бий болгож, олон талт сувгаар сурталчлах
- МХХТ-ийг ашиглаж, иргэдийн мэдээлэл авах, санал хүргэх, орон нутагтаа тулгарч буй асуудлуудыг шийдвэрлүүлэх хуулийн болон техникийн боломжуудыг сурталчлах
- ТХО болон эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээг таниулахад бүх тал (иргэд, ИНБ, төр)-ын ойлголт, оролцоо, үүрэг, ач холбогдол, практик туршлагыг тогтмол сурталчлах.



#### Дөрөв. Суралцах/туршлага судлах/хуваалцах

- Олон нийттэй харилцах шинэ стратеги, аргуудыг эрэлхийлж, тогтмол суралцах
- МХХТ-д суурилсан иргэдийн оролцоог үр дүнтэй болгох арга аргачлалд суралцах
- Мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх шинэ арга, аргачлалыг нэвтрүүлэх
- Иргэдээс ирсэн саналыг ил тод харуулах, шийдвэрлэж буй үйл явцыг ил тод, нээлттэй, хариуцлагатай байдлыг дэмжиж, мэдээлдэг практик судлах
- Олон улсын сайн туршлагуудыг судалж, орон нутагтаа нутагшуулах.

### Иргэний нийгмийн байгууллагуудад өгөх ЗӨВЛӨМЖ

ИНБ-ууд үндсэн **гурван** чиглэлээр ажиллахыг зөвлөж байна.

#### Нэг. МХХТ болон мэдээллийн сувгуудыг үр дүнтэй ашиглах

- Төрийн байгууллагуудын цахим болон олон нийтийн сүлжээ хуудсууд дээрх цаг үеийн мэдээллүүдтэй цаг алдалгүй танилцах
- ТХО болон эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээг сайжруулахад иргэдийн оролцоог МХХТ-ийн тусламжтайгаар дамжуулан хангах шинэ практик арга замуудыг эрэлхийлж, суралцах
- МАСАМ 2 төслийн багтай нягт уялдаа холбоотой ажиллах

#### Хоёр. Нөлөөлөх

- Орон нутгийн төсөвт мэдээллийн технологи, харилцаа холбооны асуудлыг шийдвэрлэх төлөвлөгөө, төсвийг тусгахад нөлөөлөх
- МХХТ-ийг ашиглаж, мэдээлэл авах, саналаа хүргүүлэх, орон нутагтаа тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлүүлэх хуулийн болон бусад механизм, боломжуудыг иргэдийн дунд сурталчлах
- Төрийн байгууллагуудын ТХО-тай мэдээлэл, түүний эх сурвалжуудыг олон нийтийн сүлжээгээр мэдээлэх, мэдээллийг тогтмол шинэчлэхэд нөлөөлөх
- Идэвх, оролцоо сул байгаа залуучууд, эрэгтэйчүүдийн нас, хүйсийн онцлогт тохируулан харилцах хуудас, харилцааны арга хэлбэр, платформыг бий болгох, сурталчлах

#### Гурав. Идэвх санаачилгатай байх

- Иргэдийн нас, хүйс, ажил мэргэжлийн онцлогт тохируулан ТХО, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний талаарх мэдээ мэдээллээр хангах
- Төрийн байгууллагуудтай бүтээлчээр хамтран ажиллах арга зүйд суралцах, харилцан ярилцах, туршлага судлах
- Олон улсад болоод Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагын ойлголт, арга хэрэгслийг ашигласан сайн жишээнүүдээс суралцах.

## ТӨЛӨВЛӨГӨӨТ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- АЙМГУУДЫН ИРГЭДИЙН ТӨСӨВ ХИЙХ
- ИНБ-УУДЫГ ЧИГЛҮҮЛЭН ЗӨВЛӨХ
- ИНБ-УУДЫН ОРОЛЦООТ ТӨСВИЙН МОНИТОРИНГ ХИЙХ
- ТӨСЛИЙН ЦАХИМ ХУУДАС ХӨГЖҮҮЛЭХ
- ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭХ
- ОЛОН НИЙТИЙН МЭДЛЭГ ОЙЛГОЛТЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙГ ТӨРӨЛ БҮРИЙН СУВГААР ДАМЖУУЛАХ
- ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА ӨРНҮҮЛЭХ



**"НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГА" НҮҮР НОМЫН ХУУДАСТ ЛАЙК ДАРЖ БИДЭНТЭЙ НЭГДЭЭРЭЙ!**



**Like & Share**

***"MASAM II төсөл хэрэгжүүлэгч, хамтран хэрэгжүүлэгчид төрийн болон ИНБ-уудтай нягт хамтран ажиллахыг зорьж байна."***

MASAM II төслийг хамтран хэрэгжүүлэгчид Глоб Интернэшнл төв, Дэлхийн Зөн Монгол ОУБ, Хүүхдийг Ивээх Сан нь төслийн хэрэгжих хугацаанд, бүхий л үйл явцад хариуцсан аймаг, дүүргүүдийнхээ иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллахыг зорьж байна. Тухайлбал, аймаг, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн төвүүд болоод төслийн хүрэх үр дүнг сайтар ойлгосон, бие даан ажиллах сонирхолтой иргэд, ИНБ-уудтай хамтран ажиллана.